

МАЛЫН ҮРЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Бидний зорилго:

Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулан арвин ашиг шим бүхий мал сүргийг үржүүлж малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах явдал юм.



Малын зохиомол хээлтүүлэг

Арабчууд 14 дүгээр зууны эхэн үед гүүг зохиомлоор хээл авахуулах оролдлого хийсэн нь малын үржилд хүн хөндлөнгөөс оролцон зохицуулах гэсэн анхны оролдлого байсан гэж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Малын зохиомол хээлтүүлэг гэдэг нь бусдаас давамгайл үржлийн үнэт чанар бүхий шилмэл хээлтүүлэгчийн үрийг зохих технологийн дагуу авч, хадгалаад хээлтэгч малын орооны үед үр тогтоох зорилгоор нөхөн үржихүйн эрхтэн системд зохиомлоор шахах арга ажиллагаа юм. Энэхүү арга нь биотехнологийн шинжлэх ухааны хамгийн хялбар, оновчтой, хямд арга бөгөөд гэрийн тэжээвэр амьтны удам зүйг сайжруулахад түгээмэл хэрэглэгддэг.

Зохиомол хээлтүүлгийн давуу тал

- ✓ Шилмэл хээлтүүлэгчийн удам зүйн дэвшлийг богино хугацаанд олон тооны хээлтэгч малд хүртээн ашиг шим сайтай малтай болох боломжийг бий болгодог.
- ✓ Дур зоргын хээлтүүлэгт нэг бухыг сайндаа л 3-5 жил ашиглаж, хамгийн ихдээ 200 тугал авах боломжтой бол зохиомол хээлтүүлэгт ашиглах шилмэл бухнаас 100 мянга хүртэлх тугал авах боломж бий.
- ✓ Үржил ашиг шимийн сайжралтыг үр төлдөө баттай удамшуулах удам, гарваль нь тодорхой хээлтүүлэгчээс авч үрийг зохиомол хээлтүүлэгт ашигладаг. Удам гарваль тодорхой гэж тухайн малын эцэг, эх, эмэг, өвгийн болон үр төлийнхөн нь үүлдэр, угсаа, ашиг шим нөхөн үржихүйн, өсөлт хөгжилт, эрүүл мэндийн талаарх бүрэн бүртгэл, мэдээлэлд тулгуурлан шилэн сонгогдсон хээлтүүлэгчийг хэлдэг.
- ✓ Үргүйдэл сувайралтын үндсэн шалтгаан болох нөхөн үржихүйн замын эмгэг, халдвар тархахаас найдвартай сэргийлдэг. Учир нь эрүүл мэндийн бүрэн үзлэгт оруулж, эрүүл гэдэг нь батлагдсан шилмэл хээлтүүлэгчээс ариун цэвэр, эрүүл ахуйн чанд дэглэмийн дор авсан үрээр нэг удаагийн хэрэглээний цэвэр багаж, хэрэгсэл ашиглан хээлтүүлэг хийдэг.
- ✓ Үнээг хээлтүүлсэн хугацаа тодорхой тул саалинд хамрагдах хугацаа, ширгэлт төллөлт гэх мэт аж ахуйн менежментийг зөв төлөвлөхөд тустай арга.

Зохиомол хээлтүүлэг хийх арга зам нь:

- ✓ Дэлхийн хэмжээний сайжруулагч бухны үрийг зохиомол хээлтүүлэгт ашиглан малынхаа үүлдэр угсааг сайжруулах
- ✓ Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг малын нөхөн үржихүйн зохих мэдлэг, дадлага, туршлагатай, хээлтүүлгийн техникч гүйцэтгэдэг.

ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛГИЙН ЗАХИАЛГА АВЧ БАЙНА

Манай газрын Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн 11330424 утсаар болон зохиомол хээлтүүлгийн техникчтэй холбогдон захиалгаа өгч малын чанараа сайжруулах үржлийн үйлчилгээгээ аваарай.

Нийслэлд зохиомол хээлтүүлгийн талаар мэдээлэл өгөх, үйлчилгээ үзүүлэх үржүүлгийн техникчдийн байршил, холбоо барих утасны жагсаалт

Хувийн дугаар	Овог нэр	Хариуцаж буй дүүрэг	Утасны жагсаалт
1	НҮХААГ	Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс	11-330424
2	Ц. Ариунзул	ЭМАА хэлтсийн мэргэжилтэн	94249902
3	Б. Гантулга	ЭМАА хэлтсийн мэргэжилтэн	99507115
01	Х. Очирбат	УБ, БЗД, Налайх	99889573
16	Ч. Батчимэг	УБ, СХД	96684870
65	Б. Гомбодорж	УБ, ХУД	88243611
07	Л. Цэдэнсодном	УБ, СХД 21-р хороо Жаргалант тосгон	96444046
66	Д. Баттулга	УБ, СХД 21-Р хороо Нарийний хэсэг	98428975
67	Б. Нандин-Од	УБ, БЗД	89680834